



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 5/15

Батширээт сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам” –ын 4 дөхь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.4 дэх заалт, Хамтын гэрээний 2.4 дэх заалт, Соёлын сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63, А/73 дугаартай хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Соёл, Урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”- ийн 5.3 дахь заалтын дагуу албан хаагчдын ур чадварыг үнэлж, дүгнэсэн тул 01, 02, 03 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг хавсралтаар олгосугай.

2. Дээрх зардлыг цалингийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Н.Одончимэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.БОЛОРЦЭЦЭГ



Соёлын төвийн даргын 2025 оны  
12 дугаар сарын 24-ны өдрийн  
Б/15 тоот тушаалын хавсралт



Ажилтан албан хаагчдын ур чадварын нэмэгдэлийн  
Үнэлгээ, хувь, хэмжээ

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Ур чадварын үнэлгээний оноо	Нэмэгдлийн хувь
1	Н.Халиун	Бүжгийн багш	95	25%
2	Г.Батзоригтмаа	Номын санч	85	20%
3	Т.Бямбасүрэн	Үйлчлэгч	60	10%
4	Ч.Мижидсүрэн	Хөгжмийн багш	80	20%